



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 469

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газар, харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 316,341,000.00 (гурван зуун арван зургаан сая гурван зуун дөчин нэгэн мянга) төгрөгийн балансын үнэ бүхий 9 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, харьяа Прокурорын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137083349
25-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 10 дугаар сарын 21 ны өдрийн
2022 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ХАРЬЯА ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
Улсын ерөнхий прокурорын газар					
1	Ниссан кашкей, улсын дугаар 08-21 УБҮ, арлын дугаар SJNFBNJ10Z2294647	2011/2011	104,293	46,900,000.00	2,500,000.00
2	Ниссан кашкей, улсын дугаар 08-35 УБҮ, арлын дугаар SJNFBNJ10Z2368977	2011/2011	86,625	46,900,000.00	3,000,000.00
Нийслэлийн Баянгол дүүргийн прокурорын газар					
3	Ниссан санни, улсын дугаар 04-55 УНҮ, арлын дугаар MDHRBBAN17Z0002455	2012/2015	100,643	27,000,000.00	3,000,000.00
Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газар					
4	Ниссан кашкей, улсын дугаар 08-37 УБҮ, арлын дугаар SJNFBNJ10Z2370063	2011/2011	106,027	46,900,000.00	3,000,000.00
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн прокурорын газар					
5	Ниссан кашкей, улсын дугаар 08-34 УБҮ, арлын дугаар SJNFBNJ10Z2369165	2011/2011	57,417	46,900,000.00	3,000,000.00
Архангай аймгийн прокурорын газар					
6	Ниссан Патрол, улсын дугаар 08-00 АРА, арлын дугаар JN1TCSY61Z0581150	2011/2011	157,375	67,900,000.00	4,000,000.00
Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газар					
7	Ниссан кашкей, улсын дугаар 08-32 УБҮ, арлын дугаар SJNFBNJ10Z2366925	2011/2019	96,235	3,500,000.00	2,500,000.00
Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын прокурорын газар					
8	Ниссан Патрол, улсын дугаар 03-09 СБА, арлын дугаар JN1TCSY61Z0569276	2007/2008	229,444	5,000,000.00	2,000,000.00

9	Санта Фи, улсын дугаар 73-13 СЭҮ, арлын дугаар КМНSH81XCBU695827	2010/2010		25,341,000.00	3,000,000.00
Нийт дүн				316,341,000.00	26,000,000.00
				(гурван зуун арван зургаан сая гурван зуун дөчин мянга)	(хорин зургаан сая)